

АГУУЛГА

НЭГ. ТУХАЙН ЖИЛИЙН БИЗНЕС ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА.....	3
ХОЁР. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	5
ГУРАВ. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, ЦЭЦЭРЛЭГЖҮҮЛЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	7
3.1. Орчны тохижилт	7
3.2. Ногоон байгууламж	8
ДӨРӨВ. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	11
ТАВ. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ ..	12
5.1. Хатуу хог хаягдал	12
5.2. Шингэн хог хаягдал	15
ЗУРГАА. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ .	16
ДОЛОО. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	18
НАЙМ . ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛӨЛД ӨРТӨГЧ ОРШИН СУУГЧИД, ОРОЛЦОГЧ ТАЛУУДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	20
ДҮГНЭЛТ	21

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Орчны тохжилт	7
Зураг 2. Газар ухсан байдал	8
Зураг 3. Мод тарьж буй байдал	9
Зураг 4. Цэнэг усалгаа хийсэн байдал	9
Зураг 5. Үерт авсан хэсгийг сэргээж буй байдал	10
Зураг 6. Жуулчны баазын хатуу хаягдлын түр цэг.....	12
Зураг 7. Хуванцар болон шил лааз ангилаж хуримтлуулсан байдал	12
Зураг 8. Хуруу зай болон автомашины хаягдал дугуйг хуримтлуулсан байдал	13
Зураг 9. Жуулчны баазын эргэн тойронд их цэвэрлэгээ хийсэн байдал	14
Зураг 10. Ургамлан бүрхэвчийг доройтуулалгүй нөхөн сэргээж ашигласан байдал	16
Зураг 11. Баазын хашаанд туулай явж буй нь	17

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. 2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зардлын гүйцэтгэл.....	21
---	----

НЭГ. ТУХАЙН ЖИЛИЙН БИЗНЕС ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

“Хөх чоно гурав” ХХК-ийн “Хос хэрэм жуулчны бааз” нь Улаанбаатар хотоос 44 км зайд Налайх дүүргийн 1-р хорооны нутаг дэвсгэрт Горхи Тэрэлжийн Байгалийн цогцолборт газарт Тэрэлжийн гүүрний зүүн хойд талд байрладаг.

“Хөх чоно гурав” ХХК нь улсын тусгай хамгаалалттай газар нутагт жуулчны баазын зориулалтаар 1.3 га талбайд газар эзэмших зөвшөөрөл авсан бөгөөд газар ашиглах гурвалсан гэрээг Горхи-Тэрэлжийн БЦГ-ын хамгаалалтын захиргаа, Налайх дүүргийн засаг даргатай 5 жилийн хугацаатай хийж 2022 онд гурвалсан гэрээг дүгнүүлэн газар ашиглах эрхийн гэрчилгээний хугацааг сунгуулсан.

“Хос хэрэм” амралт нь Туул голын дэнжид байрладаг бөгөөд цэвэрхэн тохилог тус амралтанд албан байгууллага, анги хамт олон, найз нөхөд, гэр бүлээрээ ирж Горхи Тэрэлжийн үзэсгэлэнт байгальд эрүүл цэвэр агаарт тав тухтай амрах бүх нөхцлийг бүрдүүлсэн. “Хөх чоно гурав” ХХК нь жуулчны баазын зориулалттай 1.3 га талбайд зориулалтын дагуу аялагчид амрах байр, сууц, гэр болон бусад объектуудыг барьж байгуулсан. Амрагчдын тав тухыг хангаж бойлуур суурилуулан халуун усны асуудлыг шийдсэн нийт 26 өрөө бүхий тохилог дулаан байшингууд, дотроо 00 душтэй бөгөөд бүрэн тавилгатай 10 монгол гэртэй.

Амрагчид чөлөөт цагаа зөв боловсон өнгөрөөх хүүхдийн тоглоомийн талбай, задгай асар, сагсан бөмбөгийн талбай, элсний волейбол, караоке, ширээний теннис, билльярдтай. Мөн амралтын газрын ресторанаар үйлчлүүлж эрүүл агаарт найз нөхөдтэйгээ хорхог, боодог, шорлог, уламжлалт монгол хоол хийлгэн амрах боломжтой.

“Хос хэрэм” жуулчны бааз нь нэг ээлжиндээ 80 орчим амрагчдыг хүлээн авах хүчин чадалтай бөгөөд амралтын газрын дарга, зохион байгуулагч, тогооч, бэлтгэгч, зөөгч, бармен, 2 туслах ажилчин нийт 8 ажилтантайгаар үйл ажиллагаа явуулж байна.

2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайланд байгаль орчныг хамгаалах талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээнүүд, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын хамт тайлагнасан болно.

“Хос хэрэм” жуулчны баазын 2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайланг Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланг үндэслэн Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны

“ХОС ХЭРЭМ” ЖУУЛЧНЫ БААЗЫН 2023 ОНД ХЭРЭГЖҮҮЛСЭН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

10 дугаар сарын 29-ний өдрийн А/618 дугаар тушаал “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын дагуу боловсруулав.

ХОЁР. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Хос хэрэм жуулчны бааз нь тайлант онд төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах талаар дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсэн.

- Газрын төлөв байдал, чанарын хянан баталгааны ажлын гэрээг “Хос нахиа” ХХК-тай байгуулан ажиллаж байна.
- Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолборт газар болон Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Ойн газартай “Тусгай хамгаалалттай газар нутагт мод тарих ажлын гэрээ”-г 3 жилийн хугацаатай байгуулан ажиллаж байна.
- Хөрс, ургамалан нөмрөгийг талхлахгүй байх, цэцгийн мандал шинэчлэх, арчлах, алдрал, эвдрэлд өртсөн хөрс, ургамлыг байнга нөхөн сэргээж шинээр мод тарьсан.
- Ахуйн аливаа хог, бохир усыг ил задгай хаяхгүй байх талаар анхаарч ажилласан.
- Галын хор, багаж хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг үе шаттай шалган, хэвийн түвшинд байлгаж ажилласан,
- “Хос хэрэм” жуулчны бааз нь агаарын бохирдлыг бууруулах зорилгоор жуулчны баазын гал тогооны хэрэглээнд 2017 оноос газ хэрэглэж байгаа ба “Дашваанжил” ХХК-тай хамтран ажиллах гэрээг сунгуулан ажиллаж байна.
- Жуулчны баазын барилга байгууламжгүй хэсгийн хөрс, ургамлыг хамгаалахын тулд авто зогсоол, явган хүний зам талбайг хайрган хучилттай болгож, тоглоомын талбайг цементлэсэн тул агаар орчин бохирдохгүй.
- Жил бүр амрагчдын байрны урд болон зам дагуулан цэцгийн мандал байгуулж, мод, бут сөөг тарьсан нь сайн ургаж байна.
- Газар ашигласан төлбөрөө төлж тооцоо нийлсэн акт үйлдсэн.
- Тайлант онд байгалийн болзошгүй аюул осол/газар хөдлөлт, усны үер, салхи шуурга, аянга цахилгаан, гал түймэр, үйлдвэрлэлийн осол, халдварт өвчин тархах г.м/ гарч жуулчны баазын үйл ажиллагаа, ажилчдын эрүүл мэндэд хохирол учруулаагүй болно.
- Төслийн үйл ажиллагаанаас гарч болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулахад шаардагдах зардлыг байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд жил бүр тусган хэрэгжүүлэх, байгаль орчныг хамгаалах талаар хийсэн ажлыг холбогдох газруудад тайлагнаж байна.

“ХОС ХЭРЭМ” ЖУУЛЧНЫ БААЗЫН 2023 ОНД ХЭРЭГЖҮҮЛСЭН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

- Байгаль орчны менежментийн төлөвлөгөө, орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрт тусгасан сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээнүүдийг тайлант онд авч хэрэгжүүлсэн.
- Горхи-Тэрэлжийн БЦГ-ын хамгаалалтын захиргаа, Налайх дүүргийн ЗДТГ, 1-р хорооны Засаг дарга, Мэргэжлийн хяналтын газар, НБОГ, БОАЖЯ болон засаг захиргааны байгууллагуудтай харилцаа холбоотой ажиллаж байгаль хамгаалах арга хэмжээнүүдийг авч ажилласнаар байгаль орчинд болон, ажилчдын эрүүл мэндэд ямар нэгэн сөрөг нөлөөлөл үзүүлээгүй болно.

ГУРАВ. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, ЦЭЦЭРЛЭГЖҮҮЛЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

3.1. Орчны тохижилт

“Хос хэрэм” жуулчны бааз нь газар эзэмших зөвшөөрөлтэй талбайг бүрэн хашаажуулсан хөрсний эвдрэл, бохирдлыг бага байлгах, унаган төрх байдал алдагдахаас сэргийлж 2022 онд дээр явган хүний зам, автомашины зогсоолын талбайг арчлан тордож, хөрсний эвдрэл, бохирдлоос сэргийлж ажилласан.



Зураг 1. Орчны тохижилт

Өмнөх онуудад эзэмшил газрын сул чөлөөтэй талбайг үр ашигтай ашиглах, орчны тохижилтыг хийж автомашины зогсоол байгуулж тэмдэгжүүлэн явган хүний зам болон тоглоомын талбайг хатуу хучилттай болгосон учраас тайлант онд нэмж хатуу хучилт хийгдээгүй.

Харин эзэмшил талбайн урд хэсэгт ГТБЦГ-т нэвтрэх автозамын төлбөр авах цэг шинээр байгуулагдаж, түүний цахилгааны хэрэгцээг тус баазаас шугам татаж хангахаар хашаан доторх газрыг ухаж хөрс эвдсэн. Үүнийг баазын зүгээс нэмэлтээр 1.0 сая төгрөгний хөрөнгө гарган булах, тэгшлэх ажлыг хийсэн.



Зураг 2. Газар ухсан байдал

3.2. Ногоон байгууламж

Тус онд ГТБЦГ болон Ойн газартай гэрээ байгуулан зааж өгсөн газарт мод тарьсан.

Үүнд:

Хайлаас-1405, Шинэс-58ш, Шар хуайс-182ш, Бургас-20ш, Улиас-34ш, Гүйлс-2ш, Голт бор-1ш тарьсан ба 5.0 сая төгрөгийн зардал гаргасан байна.

Нийт 1702 ширхэг мод тарьснаас ургалт 80 орчим хувьтай, ногоон байгууламжийн арчилгаа тордолтыг сайн хийж услаж, ургуулах ажлыг ажилчдад хариуцуулан ажилласан.



Зураг 3. Мод тарьж буй байдал



Зураг 4. Цэнэг усалгаа хийсэн байдал

Дээрх ажлыг Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолборт газрын захиргаа болон Ойн газраас сонгож өгсөн хэсэгт хэрэгжүүлсэн. Гэвч зуны борооны усанд зарим хэсгээр үерт автаж, тарьсан моднууд урссан. Тиймээс үерт автаж буй хэсгийг

хамгаалах далан хийх, шуудууг өргөсгөх зэрэг ажлыг цаг алдалгүй хийж 1.5 сая төгрөг зарцуулсан.



Зураг 5. Үерт авсан хэсгийг сэргээж буй байдал

**ДӨРӨВ. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

“Хос хэрэм” жуулчны бааз байрлаж буй газар нь Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолборт газарт харъяалагдана. Жуулчны баазын эзэмшил талбайд түүх соёлын ямар нэгэн дурсгал илрээгүй. Иймд уг төслөөс түүх соёлын өвийг хамгаалах ажил хийгдээгүй болно.

ТАВ. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

5.1. Хатуу хог хаягдал

Хог хаягдлын төлбөрийг Налайх дүүргийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2013 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн 33 тоот тогтоол, Нийслэлийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2009 оны 02 дугаар сарын 04-ны өдрийн 12 тоот тогтоолын дагуу үйлчилгээний хөлсийг тооцож Налайх дүүргийн татварын хэлтэст тушаасан.

Хог хаягдлын гэрээг Налайх дүүргийн Налайх “ТОХИЖИЛТ ҮЙЛЧИЛГЭЭ” ОНӨААТҮГ-тай 2023 оны 06 сарын 26-ны өдрөөс 4 сарын хугацаагаар сунгалт хийсэн.

Манай компани 2023 оны үйл ажиллагаандаа Хог хаягдлын тухай хууль тогтоомжийг дагаж мөрдөн зориулалтын цэгээс өөр газарт хог хаягдал хаяхгүй байх, хог хаягдлыг ангилан ялгаж тээвэрлэгчид хүлээлгэн өгөх зэрэг арга хэмжээ авч ажилласан.



Зураг 6. Жуулчны баазын хатуу хаягдлын түр цэг



Зураг 7. Хуванцар болон шил лааз ангилаж хуримтлуулсан байдал

“ХОС ХЭРЭМ” ЖУУЛЧНЫ БААЗЫН 2023 ОНД ХЭРЭГЖҮҮЛСЭН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

Жуулчны баазын үйлчилгээнд ашиглаж буй машин техникийг засвар үйлчилгээг засварын газарт хийлгэж тосыг солиулсан.

Харин хуруу зай, дугуй, будгийн материал зэрэг цөөн тооны аюултай хог хаягдал гарч болзошгүй тул тусад нь хадгалж хог тээвэрлэгч байгууллагад хүлээлгэж өгнө.



Зураг 8. Хуруу зай болон автомашины хаягдал дугуйг хуримтлуулсан байдал

Мөн улирал бүр нийтийн цэвэрлэгээ хийж хог хаягдлыг цэвэрлэдэг ба хог хаягдлын гэрээний сунгалтыг хийлгэж төлбөрийг төлсөн.



Зураг 9. Жуулчны баазын эргэн тойронд их цэвэрлэгээ хийсэн байдал

5.2. Шингэн хог хаягдал

“Хос хэрэм” жуулчны бааз нь аж ахуйн нэгж байгууллагын ус бохирдуулсаны төлбөрийн гэрээг 2023 оны 09 сарын 25-ны өдөр “Налайх дүүргийн Засаг дарга”-тай 1 жилийн хугацаатай гэрээ хийж хамтран ажилласан.

Манай бааз зөвхөн дулааны улиралд ажилладаг ба сар бүр ариутгал халдваргүйтгэл тогтмол хийлгэж ажилласан.

ЗУРГАА. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ

“Хос хэрэм” жуулчны бааз нь орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн дагуу хөрс, усны дээж авч итгэмжлэгдсэн лабораторид өгч, холбогдох байгууллагуудаар дүгнэлт гаргуулсан. Стандарт хэмжилзүйн газарт хөрс, ус, хаягдал усны шинжилгээг хийлгэсэн. Уг шинжилгээгээр хөрс, усанд бохирдол илрээгүй бөгөөд хэвийн үзүүлэлттэй гарсан байна.

Жуулчны баазын үйл ажиллагааг явуулахдаа ургамлан нөмрөг хамгаалах арга хэмжээг тогтмол авч ажилладаг ба тайлант онд нэмж мод, бут тарьсан. Эзэмшил газар дахь ургамлан нөмрөгийг доройтуулалгүй ашигласан ба ойн мэргэжилтнээс зөвлөгөө авч жуулчны баазын ногоон байгууламжийг нэмэгдүүлэн ажилласан.



Зураг 10. Ургамлан бүрхэвчийг доройтуулалгүй нөхөн сэргээж ашигласан байдал

“ХОС ХЭРЭМ” ЖУУЛЧНЫ БААЗЫН 2023 ОНД ХЭРЭГЖҮҮЛСЭН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

Мөн баазын үйл ажиллагаанаас амьтны шилжилт хөдөлгөөнд саад учруулахгүйг хичээн ажилладаг ба баазын хашаанд бор туулай явах нь элбэг тохиолддог. Харин хашааны гадна талаар өөр төрлийн амьтан ажиглагдаагүй.



Зураг 11. Баазын хашаанд туулай явж буй нь

**ДОЛОО. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ
ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
БИЕЛЭЛТ**

“Хөх чоно гурав” ХХК нь Монгол улсын хууль эрхзүйн хүрээнд хийгдэх байгаль орчны тайлан, төлөвлөгөө, татвар хураамжуудыг цаг тухайд нь төлөх, хог хаягдлыг багасгах, бууруулах, ангилан хаях, усыг зохистой хэрэглэж, хэмнэх зэргээр байгууллагын хэмжээнд холбогдох арга хэмжээнүүд авч ажилласан.

MNS 6426:2013 “Тусгай хамгаалалттай газар нутаг дахь эко аялал жуулчлалын зориулалттай байр сууц, үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага” Монгол Улсын стандартын дагуу үйл ажиллагаа явуулсан бөгөөд удирдлага зохион байгуулалтын ажлын хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:

- Газрын төлөв байдал, чанарын хянан баталгааны ажлын гэрээг “Хос нахиа” ХХК-тай байгуулан ажиллаж байна.
- Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолборт газар болон Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Ойн газартай “Тусгай хамгаалалттай газар нутагт мод тарих ажлын гэрээ”-г 3 жилийн хугацаатай байгуулан ажиллаж байна.
- Хөрс, ургамалан нөмрөгийг талхлахгүй байх, цэцгийн мандал шинэчлэх, арчлах, алдрал, эвдрэлд өртсөн хөрс, ургамлыг байнга нөхөн сэргээж шинээр мод тарьсан.
- Ахуйн аливаа хог, бохир усыг ил задгай хаяхгүй байх талаар анхаарч ажилласан.
- Галын хор, багаж хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг үе шаттай шалган, хэвийн түвшинд байлгаж ажилласан,
- “Хос хэрэм” жуулчны бааз нь агаарын бохирдлыг бууруулах зорилгоор жуулчны баазын гал тогооны хэрэглээнд 2017 оноос газ хэрэглэж байгаа ба “Дашваанжил” ХХК-тай хамтран ажиллах гэрээг сунгуулан ажиллаж байна.
- Жуулчны баазын барилга байгууламжгүй хэсгийн хөрс, ургамлыг хамгаалахын тулд авто зогсоол, явган хүний зам талбайг хайрган хучилттай болгож, тоглоомын талбайг цементлэсэн тул агаар орчин бохирдохгүй.
- Жил бүр амрагчдын байрны урд болон зам дагуулан цэцгийн мандал байгуулж, мод, бут сөөг тарьсан нь сайн ургаж байна.
- Холбогдох татвар хураамжийг цаг тухайд нь төлж барагдуулж ажилласан.

“ХОС ХЭРЭМ” ЖУУЛЧНЫ БААЗЫН 2023 ОНД ХЭРЭГЖҮҮЛСЭН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

- Тайлант онд байгалийн болзошгүй аюул осол/газар хөдлөлт, усны үер, салхи шуурга, аянга цахилгаан, гал түймэр, үйлдвэрлэлийн осол, халдварт өвчин тархах г.м/ гарч жуулчны баазын үйл ажиллагаа, ажилчдын эрүүл мэндэд хохирол учруулаагүй болно.
- Баазын хашааны баруун талаар орж ирсэн үерийн хөнөөлийг арилгаж, цаашид болзошгүй үерийн аюулаас сэргийлэн далан шуудууг сэргээх ажлыг цаг алдалгүй хийсэн.
- Төслийн үйл ажиллагаанаас гарч болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулахад шаардагдах зардлыг байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд жил бүр тусган хэрэгжүүлэх, байгаль орчныг хамгаалах талаар хийсэн ажлыг холбогдох газруудад тайлагнаж байна.
- Байгаль орчны менежментийн төлөвлөгөө, орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрт тусгасан сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээнүүдийг тайлант онд авч хэрэгжүүлсэн.
- Горхи-Тэрэлжийн БЦГ-ын хамгаалалтын захиргаа, Налайх дүүргийн ЗДТГ, 1-р хорооны Засаг дарга, Мэргэжлийн хяналтын газар, НБОГ, БОАЖЯ болон засаг захиргааны байгууллагуудтай харилцаа холбоотой ажиллаж байгаль хамгаалах арга хэмжээнүүдийг авч ажилласнаар байгаль орчинд болон, ажилчдын эрүүл мэндэд ямар нэгэн сөрөг нөлөөлөл үзүүлээгүй болно.
- Налайх дүүргийн Засаг даргатай Хамтран ажиллах гэрээг 2023 оны 10 сарын 17-нд байгуулсан.
- Ахуйн шавьж, мэрэгч устгах, халдваргүйжүүлэлт хийх тухай гэрээг 2023 оны 06 сарын 25-нд “Нандин-Өргөө” ХХК-тай байгуулсан гэрээг сунгуулж ажилласан,
- Хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх үйлчилгээний гэрээг Налайх дүүргийн “Тохижилт үйлчилгээ” ОНӨААТҮГ-тай 2023 оны 06 сарын 26-нд 4 сарын хугацаатай сунгуулсан,
- Аж ахуйн нэгж байгууллагын бохир ус татан зайлуулах гэрээг 2023 оны 06 сарын 26-нд “Чандмань Налайх” ОНӨААТҮГ-тай 1 жилийн хугацаатай гэрээ байгуулсан,
- Горхи-Тэрэлжийн БЦГ-ын хамгаалалтын захиргаа, Налайх дүүргийн ЗДТГ, Мэргэжлийн хяналтын газар, Нийслэлийн БОГ болон засаг захиргааны байгууллагуудтай байнгын харилцаа холбоотой ажилласан;
- Хог хаягдлыг багасгах, бууруулах, ангилан хаях, усыг зохистой хэрэглэх талаар ажилчдад сургалт зохион байгуулж, жуулчны баазад анхааруулга, санамжуудыг байрлуулсан.

**“ХОС ХЭРЭМ” ЖУУЛЧНЫ БААЗЫН 2023 ОНД ХЭРЭГЖҮҮЛСЭН БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

- Ажилчдын хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангаж байгууллагын дотоод дүрэм журам, анхааруулга, санамжийг мөрдөж ажилласан.

**НАЙМ . ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛӨЛД ӨРТӨГЧ ОРШИН СУУГЧИД,
ОРОЛЦОГЧ ТАЛУУДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

2023 онд гүйцэтгэсэн ажлын тайлан болон баазын ногоон байгууламжийн тайланг Горхи-Тэрэлжийн БЦГ-ын хамгаалалтын захиргаанд тайлан хэлбэрээр гаргаж өгсөн. Мөн Нийслэлийн Байгаль орчны газарт тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг дүгнүүлэхээр хандаад байна.

**“ХОС ХЭРЭМ” ЖУУЛЧНЫ БААЗЫН 2023 ОНД ХЭРЭГЖҮҮЛСЭН БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

ДҮГНЭЛТ

Жуулчны баазын байгаль хамгаалах чиглэлийн ажлуудыг орхигдуулалгүй хийсэн. Тайлант онд жуулчны баазын “Газрын төлөв байдал, чанарын хянан баталгааны ажлын тайлан”-г хийлгэхээр гэрээ байгуулан ажиллаж байна.

Хүснэгт 1. 2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зардлын гүйцэтгэл

№	Зардлын ангилал		Төсөв, мян.төг
1.	Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээ	Агаарын бохирдлыг бууруулахад хийн түлш	250.0
		Газар ашигласны жилийн төлбөр	1177.0
		Хаягдал усны шинжилгээний төлбөр	84.7
2.	Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлт	Ногоон байгууламжийн арчилгаа, мод нэмж тарих	2000.0
3.	Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт		-
4.	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт	Хог хаягдлын төлбөр	220.0
5.	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт		6500.0
6.	Орчны хяналт, шинжилгээний хөтөлбөр		133.7
7.	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах		50.0
Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн нийт төсөв, мян.төг			

“Хөх чоно гурав” ХХК-ийн Хос хэрэм жуулчны бааз нь 2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтэд 10415.4 мянган төгрөг зарцуулсан байна.